



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 дугаар сарын 14 өдөр Дугаар 26.

Хэрлэн сум

XXVI ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын өргөтгөсөн хурал 2020 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 88.3 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг даалгаврын өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1.15,000 ширхэг даавуун амны хаалтын нөхөн хангалт хийх тооцоо, оёдолчдын урамшууллын талаар танилцуулах: Эрүүл мэндийн газар,

2.Цэрэг татлагын үйл ажиллагаанд шаардагдах амны хаалт, ариутгалын бодис, материалын тооцоог танилцуулах: Цэргийн штаб,

3.Хэрлэн сумын хэмжээнд олон нийтийн эргүүлийг зохион байгуулах хуваарь, эргүүлийн бүрэлдэхүүний амны хаалт, гар ариутгагч, ханцуйн тэмдэг, шатахууны тооцоог танилцуулах: Боловсрол, соёл, урлагийн газар,

4.Гэр хорооллын хогийг цэвэрлэх ажлыг нэгдсэн журмаар зохион байгуулах, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудыг татан оролцуулах, шаардагдах зардлын тооцоог гаргаж танилцуулах, АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс.

ТАНИЛЦУУЛСАН НЬ:

1.Улсын Онцгой комиссын 2020 оны 07 дугаар тогтоолыг танилцуулах: /Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах/,

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

1.1.Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/160 дугаар захирамжийн 1 дүгээр заалтыг Улсын Онцгой комиссын 2020 оны 07 дугаар тогтоолын дагуу 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгахыг,

Хоёр. Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

2.1.15,000 ширхэг амны хаалт оёход шаардагдах материалын зардалд даавуу, резин, утас, уут худалдан авахад 6,644,000 төгрөг, Улаанбаатар хотоос материал худалдан авах ажлын хэсгийн 2 гишүүний томилолт, тээврийн зардал 550,800 төгрөг нийт 7,194,800 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

2.2.Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ирүүлсэн хүсэлтийг хэлэлцэж шийдвэрлэсний дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 12,984 иргэн тус бүрт нэг ширхэг амны даавуун хаалтыг аймгийн Амны хаалтын нөөцөөс олгохыг,

2.3.Нийтийн эргүүлийг зохион байгуулах алба хаагчдад амны хаалт, гар ариутгагч, шатахуун, ханцуйн тэмдэг хийхэд шаардагдах 6,487,800 төгрөгийн зардлыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

2.4.Цэрэг татлагын үйл ажиллагаанд шаардагдах нэг удаагийн амны хаалт-850 ширхэг, гар ариутгагч /250мл/-37 ширхэг, бээлий-10 хайрцаг, халдваргүйтгэлийн бодис /Жавелион/-1 хайрцаг /таб/ тус тус Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

Гурав. АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ, Хэрлэн сумын Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир, “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ-ын дарга Б.Тэгшжаргал нарт:

3.1.Гэр хорооллын айл өрхийн хог, хаягдлыг цэвэрлэх ажлыг нэгдсэн журмаар зохион байгуулах, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулах, шаардагдах зардлын тооцоог гаргаж аймгийн Онцгой комиссын дараагын хурлаар танилцуулахыг,

3.2.Гэр хорооллын айл өрхийн хог, хаягдлыг цэвэрлэх ажилд Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажил хайгч иргэд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн иргэдийг татан оролцуулахыг,

3.3.Гэр хорооллын хог, хаягдлыг цэвэрлэх ажлын хэсгийг байгуулж Хэрлэн сумын Засаг даргын орлогч О.Пүрэв-Очиороор ахлуулан “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ-ын дарга Б.Тэгшжаргал нарийн бичгээр томилгоожуулан ажиллахыг,

3.4.Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар, “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ-аас тус бүр нэг албан хаагчийг ногоон байгууламж, гэр хорооллын айл өрхүүдийн хог хаягдалд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллахаар цалинжуулж томилгоожуулахыг,

Дөрөв.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа, Гаалийн газрын дарга Б.Гэрэлт-Од, Хилийн анги нэгтгэлүүдийн дарга, захирагч нарт:

4.1.ОХУ, БНХАУ-тай харилцдаг Эрэнцав, Баянхошуу хилийн боомтуудын ариутгал халдваргүйтгэлийн ажлыг чанартай гүйцэтгэж ажиллахыг,

Тав.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа, Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

5.1. Хилийн боомт бүхий Халхгол сум, Ялалт баг, Чулуунхороот сум, Матад сум, Газрын тосны XIX, XXI талбай болон уул уурхай газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэх авто, төмөр зам дагуух айл өрх, малчдад мэдээ мэдээлэл өгөх, тухайн сумдын Онцгой комиссын үйл ажиллагаатай танилцан зөвлөмж өгөх, холбогдох аж ахуйн нэгж байгууллагуудад "Covid-19" халдвараас урьдчилан сэргийлэх ажлын явц байдалтай танилцан аймгийн Онцгой комисст 2020 оны 04 дүгээр сарын 21-ний дотор танилцуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА

М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.БАТТУЛГА